



In partnership with
Canada



ЁС ЗҮЙН ДЭД БҮТЭЦ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЁС ЗҮЙН ИНДЕКС НЭВТРҮҮЛЭХ НЬ

Эм Эм Си Жи ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Ч.Даваасүрэн

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах, туршлага солилцох сургалт, уулзалтад зориулан бэлтгэв.

2026.06.15



Агуулга

- 1 ЁС ЗҮЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
- 2 ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА
- 3 ЁС ЗҮЙН ИНДЕКС НЭВТРҮҮЛЭХ НЬ

НЭГ

ЁС ЗҮЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ethics

PRINCIPLE


Ёс зүйн дэд бүтэц гэж юу вэ?

Төрийн удирдлага, нийтийн захиргааны онолд **Ёс зүйн дэд бүтэц** (Ethics Infrastructure) гэдэг нь:

“Төрийн албан хаагчдыг ёс зүйтэй, шударга, нийтийн ашиг сонирхолд нийцсэн байдлаар ажиллахад чиглүүлж, дэмжиж, хянаж, хариуцлага тооцох институц, хууль эрх зүй, удирдлага, соёлын цогц тогтолцоо юм.”



Энэ ойлголт хэзээ, хэрхэн үүссэн бэ?



Ёс зүйн дэд бүтцийн бүрэлдэхүүн



Анхны үзэл
баримтлал

1. Удирдан чиглүүлэх (Guidance)

Төрийн албан хаагчид юу зөв,
юу буруу болохыг ойлгуулах

Үнэт зүйлс

Ёс зүйн дүрэм

Сургалт

Удирдлагын манлайлал

2. Удирдах, хянах (Management and Control)

Ёс зүйн хэм хэмжээг
мөрдүүлэх механизм.

Хууль тогтоомж

Ашиг сонирхлын зөрчлийн
зохицуулалт

Дотоод хяналт

Аудит

Ил тод байдал

3. Хариуцлага тооцох (Accountability)

Зөрчил гарсан үед илрүүлж,
шийдвэрлэх тогтолцоо.

Сахилгын арга хэмжээ

Гомдол мэдээллийн систем

Хяналтын байгууллагууд

Шүүхийн хяналт

Олон нийтийн хяналт

Орчин цагт

зөвхөн дүрэм журам биш

Үнэт зүйлс	Институтц	Процесс	Хариуцлага
Төрийн албаны зарчим, соёл	Ёс зүйн зөвлөл, хяналтын байгууллага	Мэдүүлэг, тайлагнал, сургалт	Хяналт, шалгалт, шийтгэл

Ёс зүйн дэд бүтцийн хөгжлийн хандлага



1996

2000

2017

2026

Ёс зүйн дэд бүтэц
(Ethics infrastructure)

Үндэсний шударга
байдлын тогтолцоо
(National integrity system)

Нийтийн шударга
байдлын хүрээ
(Public integrity framework)

Ёс зүйн индекс
(Ethics / integrity index)

Гол зорилго	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Нийгмийн бүх институтийн шударга байдлыг хангах	Ёс зүйн соёл ба үнэт зүйлийг төлөвшүүлэх	Байгууллагын ёс зүйн чадавх, шударга байдал, эрсдэлийг үнэлэх
Фокус	- Ёс зүйн дүрэм - Хууль эрх зүй - Хяналт - Хариуцлага - Сургалт	- Төр - Шүүх - Аудит - Иргэний нийгэм - Хэвлэл мэдээлэл - Хувийн хэвшил - Сонгуулийн байгууллага	- Тогтолцоо - Соёл - Хариуцлага	- Манлайлал - Ёс зүйн соёл - Шударга байдал - Эрсдэлийн удирдлага - Хариуцлагын тогтолцоо
Түлхүүр үг	Ёс зүй	Шударга байдал	Үнэ цэн, соёл	Хэмжих, сайжруулах
Онцлог	- Дүрэмд суурилсан - Зөрчил гарсны дараа арга хэмжээ авах - Авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн	- Системийн түвшинд авч үздэг - Авлигын эсрэг өргөн хүрээний загвар - Байгууллагын дотоод ёс зүйн менежментийг бага авч үздэг	- Үнэт зүйлд суурилсан - Соёл, зан төлөвт анхаардаг - Эрсдэлийн удирдлага - Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн	Тоон хэмжилт, харьцуулалт Эрсдэлийг эрт илрүүлэх Сайжруулалт хийхэд чиглэсэн Бодлого, гүйцэтгэлтэй уялдана

Дүрэм мөрдүүлэх

Шударга байдлын
тогтолцоог бүрдүүлэх


Ёс зүйн соёл, үнэт
зүйлийг төлөвшүүлэх

Хэмжих, сайжруулах

Эх сурвалж:
OECD. (1996). *Ethics in the Public Service: Current Issues and Practice*. Paris: OECD Publishing.
OECD. (2017). *Recommendation of the Council on Public Integrity*. Paris: OECD Publishing.
Pope, J. (2000). *Confronting Corruption: The Elements of a National Integrity System*. Berlin: Transparency International.

Хамгийн сүүлийн үеийн, хамгийн их хэрэглэгдэж байгаа материалууд

OECD Recommendation on Public Integrity (2017)



- Ethics Infrastructure (1996) гэсэн тодорхойлолт нь Public Integrity System (2017) болж өөрчлөгдсөн.
- Public integrity = shared ethical values, principles and norms that prioritise the public interest over private interests.

OECD Public Integrity Handbook (2020)




- OECD Recommendation on Public Integrity (2017)-г хэрэгжүүлэх практик гарын авлага
- Ёс зүйн дэд бүтэц гэсэн хуучин ойлголтыг өргөжүүлж нийтийн албаны шударга байдлын тогтолцоо болгон тайлбарласан.
- 13 зарчим, хэрэгжилтийн аргачлал, институцийн загваруудыг багтаасан.

OECD Public Integrity Indicators (PII) (2024–2026)



улс орны шударга байдлын тогтолцоог хэмжих үзүүлэлтүүдийг харуулдаг.

SIGMA Public Integrity Framework



Стратеги, Бодлого боловсруулах, зохицуулах, Төрийн үйлчилгээ болон хүний нөөцийн менежмент зэрэг 6 бүлэг үзүүлэлтээр үнэлгээ хийдэг.

OECD Anti-Corruption and Integrity Outlook 2024, 2026



- Аль улс ямар тогтолцоо хэрэглэж байна
- Ямар сайн туршлага байна
- Ямар сул тал нийтлэг байна гэдгийг харьцуулан харуулдаг.

Transparency International – Public Integrity Topic Guide



ХОЁР

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ethics

PRINCIPLE

Олон улсын харьцуулалт, дүгнэлт



62 улсын шударга байдлын тогтолцоог 7 үндсэн чиглэлээр харьцуулсан байдаг. Үүнд:

- Авлигын эсрэг ба шударга байдлын стратеги
- Лоббины зохицуулалт
- Ашиг сонирхлын зөрчил
- Улс төрийн санхүүжилт
- Мэдээллийн ил тод байдал
- Шүүхийн шударга байдал
- Төрийн албан хаагчийн сахилгын тогтолцоо

Гол дүгнэлтүүд

1 Дүрэм журам сайжирсан ч хэрэгжилт хоцорч байна

- Олон улс оронд дүрэм журам харьцангуй сайн хөгжсөн боловч хэрэгжилт нь мэдэгдэхүйц хоцорч байна.
- OECD орнуудад **зохицуулалтын дундаж үнэлгээ 63%**, харин **бодит хэрэгжилт 44%** байгаа нь 19 нэгж хувийн зөрүүтэй байна.
- Орчин үеийн ёс зүйн дэд бүтцийн гол сорилт нь дүрэм журам бий болгох бус, харин түүний хэрэгжилтийг хангах явдал болж байна.

"Асуудал нь дүрэм журам дутмагдаа бус, харин хэрэгжилтийн чадавх, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоонд байна."

2

Авлигын эсрэг стратегиудын хэрэгжилтийг хэмждэггүй

OECD-ийн гишүүн орнуудын зөвхөн 25 орчим хувь нь авлигын эсрэг стратегийн хэрэгжилтээ тогтмол хэмжиж, хянадаг.

Өөрөөр хэлбэл ихэнх улс стратеги баталдаг боловч үр дүнгээ хэмждэггүй байна.

3

Өндөр эрсдэлтэй салбарууд хамгаалалт сул хэвээр байна

Улс орнуудын анхаарал ихэвчлэн төрийн байгууллага дээр төвлөрсөн байдаг боловч дараах эрсдэлтэй салбарууд орхигдож байна:

- Төрийн өмчит компаниуд
- Төр-хувийн хэвшлийн түншлэл (PPP)
- Худалдан авах ажиллагаа
- Эрүүл мэндийн салбар
- Татварын удирдлага
- Томоохон дэд бүтцийн төслүүд

4

Шүүхийн шударга байдал шинэ тэргүүлэх асуудал болж байна

2026 оны тайланд анх удаа шүүгчдийн ашиг сонирхлын мэдүүлэг, прокурорын ёс зүй, шүүхийн хараат бус байдал зэрэг үзүүлэлтийг авч үзсэн. Шүүхийн байгууллагын шударга байдлын тогтолцоо олон оронд сул хэвээр байна.

Олон улсын харьцуулалт, дүгнэлт

Гол дүгнэлтүүд

5 Технологи, өгөгдөл ашиглах нь хамгийн том боломж болж байна

OECD-ийн үзэж байгаагаар дараагийн шатны шинэчлэл нь шинэ хууль биш харин:

- өгөгдөлд суурилсан хяналт,
- цахим мэдүүлэг,
- эрсдэлийн шинжилгээ,
- Хиймэл оюун ашиглан илрүүлэх

Гэвч олон улс энэ боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

6 Шударга байдал бол зөвхөн ёс зүйн асуудал биш, эдийн засгийн давуу тал юм

Тайлангийн гол мессеж нь шударга байдлыг зардал биш, өрсөлдөх чадварын давуу тал гэж харах.

Шударга төрийн байгууллагууд:

- хөрөнгө оруулалт татдаг,
- төрийн үйлчилгээний чанарыг сайжруулдаг,
- иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг,
- төсвийн үр ашгийг өсгөдөг гэж дүгнэсэн.

Зөвлөмжүүд

1 Дүрэм боловсруулахаас хэрэгжилтэд шилжих

Гол анхаарал:

- шинэ хууль батлах
- шинэ журам гаргах



- хэрэгжилт
- мониторинг
- үнэлгээ



2 Эрсдэлд суурилсан хандлага хэрэглэх

Нөөцөө бүх салбарт жигд бус, хамгийн эрсдэлтэй хэсэгт төвлөрүүлэх. Тухайлбал:

- худалдан авах ажиллагаа
- төрийн өмчит компани
- дэд бүтцийн төсөл
- татвар
- лиценз олголт

3 Өгөгдөл ба технологийн хэрэглээг нэмэгдүүлэх

- хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим болгох
- автомат хяналт хийх
- өгөгдөлд суурилсан эрсдэлийн үнэлгээ ашиглах

4 Шүүх болон сахилгын тогтолцоог бэхжүүлэх

- ашиг сонирхлын мэдүүлэг
- сахилгын шийдвэрийн ил тод байдал
- хараат бус хяналт зэргийг сайжруулах

5 Авлигын эсрэг стратегийг хэмждэг болох

Стратеги бүр:

- хэмжигдэх зорилттой,
- шалгуур үзүүлэлттэй,
- хэрэгжилтийн тайлантай,
- хөндлөнгийн үнэлгээтэй байх ёстой.

Олон чиглэлээр тогтмол сайн үзүүлэлттэй, сайн туршлагаараа онцлогддог улсууд

Финланд



Онцлог

- Үндэсний хэмжээний integrity strategy-тай болсон шинэ үеийн орнуудын нэг.
- Авлигын эсрэг бодлогыг төрийн албаны шинэчлэл, ил тод байдалтай холбодог.
- Өндөр түвшний **иргэдийн итгэлцэл дээр суурилдаг.**

“Ёс зүйг сахилгын асуудал бус, байгууллагын соёлын асуудал гэж үздэг.”

Нидерланд



Онцлог

- **Дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, аудитын тогтолцоо маш хүчтэй.**
- Сангийн яамны дэргэд дотоод хяналт болон дотоод аудитыг нэг мөр стандартчилдаг төв нэгжтэй.
- Бүх яам жил бүр аудитад хамрагддаг.

“Integrity + Risk Management + Internal Audit гэсэн гурван тогтолцоог нэгтгэн удирддаг.”

Монголын төрийн албанд хамгийн ойр хэрэгжүүлэх боломжтой туршлагын нэг.

Их Британи



Онцлог

- Лоббины зохицуулалт OECD-ийн дунджаас үлэмж өндөр.
- Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, хэрэгжилтийн үзүүлэлт маш өндөр.
- Committee on Standards in Public Life, National Audit Office зэрэг институцууд хүчтэй ажилладаг.

“Ёс зүйн зөвлөмж гаргадаг хараат бус байгууллага + аудитын байгууллага + парламентын хяналтын хослол.”

БНСУ



Онцлог

- Авлигын эсрэг болон шударга байдлын үндэсний стратеги нь төрийн болон хувийн хэвшлийг хамардаг.
- Шударга байдлын үнэлгээ (Integrity Assessment)-г байгууллага бүр дээр тогтмол хийдэг.
- Авлигатай тэмцэх болон Иргэний эрхийн комисс (ACRC) төв институц болж ажилладаг.

“Ёс зүйн бодлого, гомдол шийдвэрлэлт, авлигын эсрэг хяналтыг нэг байгууллагад төвлөрүүлсэн.”

Монголтой институцийн орчны хувьд харьцуулахад хамгийн ойр жишээ.

Шинэ Зеланд



Онцлог

- Rule-based биш, value-based хандлага давамгайл.
- Төрийн албан хаагчдад дүрэм мөрдүүлэхээс илүү үнэт зүйл төлөвшүүлэхэд анхаардаг.
- Public Service Commission нь төрийн албаны үнэт зүйлсийг удирддаг.

“"Spirit of the law" буюу хууль мөрдөхөөс гадна нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэх соёлыг хөгжүүлдэг.”

OECD Outlook-д байнга сайн жишээ болон дурдагддаг.

Канад




Онцлог

- Conflict of Interest and Ethics Commissioner гэсэн бие даасан институцтэй.
- Ашиг сонирхлын зөрчлийг урьдчилан сэргийлэхэд төвлөрдөг.
- Төрийн удирдах албан тушаалтанд зориулсан тусгай ёс зүйн дэглэмтэй.

“Хариуцлага тооцохоос илүүтэй урьдчилан сэргийлэх тогтолцоо хүчтэй.”

Улс бүрийн туршлагаас авах элементүүд



ГУРАВ

ЁС ЗҮЙН ИНДЕКС НЭВТРҮҮЛЭХ НЬ

ethics

PRINCIPLE

Ёс зүйн индекс тооцох зорилго

1. Одоогийн нөхцөл байдлыг хэмжих (Diagnostic)

Төрийн албаны ёс зүйн орчин, шударга байдлын тогтолцоо ямар түвшинд байгааг үнэлэх.

2. Сул тал, эрсдэлийг илрүүлэх (Risk Identification)

Ёс зүйн эрсдэл хамгийн өндөр байгаа байгууллага, салбар, үйл ажиллагааг илрүүлэх.

3. Байгууллагуудыг харьцуулах (Benchmarking)

Яам, агентлаг, аймаг хооронд харьцуулж, сайн туршлага, сул талыг тодорхойлох

4. Шинэчлэлийн үр дүнг хэмжих (Monitoring)

Ёс зүйн бодлого үр дүнтэй хэрэгжиж зорилтдоо хүрсэн эсэхийг үнэлэх.

5. Иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх (Public Accountability)

Ил тод байдлыг нэмэгдүүлэх, байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор индексийг ил тод зарладаг.

OECD Public Integrity Framework:

Төрийн албан хаагчдыг ёс зүйтэй ажиллах боломжийг бүрдүүлж буй тогтолцооны төлөвшил, хэрэгжилтийн түвшнийг хэмжих, сайжруулахад оршино.

Монгол Улсын хувьд ёс зүйн индекс тооцох зорилго юу байх вэ?

Арга зүйн хувьд эхлээд:

"Энэ индексийг ямар шийдвэр гаргахад ашиглах вэ?"

Өөрөөр хэлбэл,

"Яах гэж энэ индексийг тооцох гэж байгаа вэ?"

гэдгээ тодорхойлох ёстой.

Нөгөө талаас ёс зүйн индекс гэж юуг ойлгох талаарх тодорхойлолтыг гаргах нь зүйтэй.

Ёс зүйн индекс гэж юу вэ?

- Олон улсад "Ethics Index" буюу "Ёс зүйн индекс" гэсэн **нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэг мөр албан ёсны тодорхойлолт байдаггүй. Учир нь ёс зүй бол шууд хэмжигдэх зүйл биш.**
- Тиймээс олон улсын байгууллагууд Ethics Index, Integrity Index, Public Integrity Index, Ethics Climate Index, Ethical Culture Index гэх мэт нэр томьёо хэрэглэдэг боловч тэдгээрийн **тодорхойлолт нь зорилго, хэмжих түвшнээсээ хамаарч өөр өөр байдаг.**

Өргөн хүрээний тодорхойлолт нь:

Ёс зүйн индекс гэдэг нь төрийн байгууллага болон төрийн албан хаагчдын ёс зүйн үнэт зүйл, зан үйл, ёс зүйн дэд бүтэц, шударга байдлын тогтолцооны төлөвшил, хэрэгжилтийн түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн нийлмэл хэмжүүр юм.

Хэрэв индекс байгууллагын түвшинд гаргах гэж байгаа бол

Төрийн байгууллагын ёс зүйн индекс гэдэг нь ёс зүйн үнэт зүйлс, институцийн зохион байгуулалт, хэрэгжилтийн процесс болон хяналт-хариуцлагын тогтолцооны төлөвшил, хэрэгжилтийн түвшнийг хэмжих нийлмэл үзүүлэлт юм.

OECD-ийн товч тодорхойлолт

Ёс зүйн индекс нь төрийн байгууллагын шударга байдлын (public integrity) тогтолцоо хэр төлөвшиж, хэрэгжиж байгааг хэмжих нийлмэл үзүүлэлт юм.



"Төрийн албан хаагч хэр ёс зүйтэй хүн бэ?"

гэдгийг хэмжихгүй.



Төрийн байгууллага ёс зүйтэй ажиллах орчин, тогтолцоог хэр бүрдүүлсэн бэ?

гэдгийг хэмжинэ.

Индекс (Index) гэдэг нь харьцуулах боломжгүй тоо мэдээллийг харьцуулахуйц хэлбэрт оруулж цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийг хэмжих тоон үзүүлэлт юм.

Ёс зүйн индекс тооцох үндэслэл



УИХ-ын 2024 оны
27 дугаар тогтоол

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс
урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
үндэсний хөтөлбөр /2024-2030 он/

Зорилго 4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.

Зорилт 4.2. Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн үнэлгээг чанаржуулна.

4.2.3. **төрийн албаны ёс зүйн индексийг нэвтрүүлэх** ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.



4.2.1. төрийн албан дахь **ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг** жил бүр зохион байгуулж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшинэ.

4.2.2. байгууллага **ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг жил бүр судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон** зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.



УИХ-ын 2024 оны
21 дүгээр тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2024-
2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

4.2.3. Төрийн албаны шинэчлэл

4.2.3.13. **Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.**



Төрийн албан хаагчийн ёс
зүйн тухай хууль (2023)

Хоёрдугаар бүлэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага

6 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим

7 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ

8 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага

**Гуравдугаар бүлэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс
урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

9 дүгээр зүйл. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

**Дөрөвдүгээр бүлэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх
эрх бүхий этгээд, түүний бүрэн эрх**

Тавдугаар бүлэг. Гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

**Зургаадугаар бүлэг. Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага
хүлээлгэх**

Долоодугаар бүлэг. Бусад зүйл

Ижил төстэй индекс тооцож байсан туршлага

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.



Монгол Улсын Авлигын
индексийн тооцооны үр дүн
- 2009, 2011, 2013 он



Төрийн байгууллагын
шударга байдлын үнэлгээ -
2010, 2012, 2014 он

2015 оноос хойш

Төрийн байгууллагын
шударга байдлын
үнэлгээ (2015-2025)

Гадаад шударга
байдлын үнэлгээ

Авлигын индекс

Ил тод хариуцлагатай
байдлын индекс

Дотоод шударга
байдлын үнэлгээ

Соёлын индекс

Үүргээ шударгаар гүйцэтгэх
байдлын индекс

Бодлогод
оролцогчдын
үнэлгээ

Авлигын талаарх төсөөлөл,
бодит тохиолдол

Авлигыг хянах механизм

Удирдлагын хүсэл
эрмэлзэл

Анхаарал хандуулсанд баярлалаа



Асуулт байна уу?